

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-17

1. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 2 гишүүн 2024.04.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	7-9
2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	9
3. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	9
4. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	9-14
5. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	14-17

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 02-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 00 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар,
Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Х.Булгантуяа, Д.Өнөрболор;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд.

Нэг.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 2 гишүүн 2024.04.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батбямба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн талаар Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Жавхлан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн нэрийн “, өөрчлөлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн 4 дүгээр зүйлд, доор дурдсан агуулгатай 4.1.5 дахь хэсэг” гэснийг “хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт” гэж, 4.1.5 дахь заалтын дугаарыг “4.1.6” гэж тус тус өөрчлөн, мөн заалтыг төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт:

4.1.6.чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус.

Тайлбар: “төрөл бүрийн ундаа, ус” гэдэгт үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар ашиглах байгалийн гаралтай өтгөрүүлсэн шүүс, нунтаг баяжмал хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 7 дахь заалт:

7	Чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус	1 литр
---	--	--------

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг:

6.9.Энэ хуулийн 4.1.6-д заасан чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/			
			2027 он	2028 он	2029 он ба түүнээс хойш	
1	Чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус	100 мл-т агуулагдах чихэр, чихэр орлуулагч 0-5 гр	1 литр	0	0	0
		100 мл-т агуулагдах чихэр, чихэр орлуулагч 5 гр-с дээш	1 литр	500 төгрөг	525 төгрөг	550 төгрөг

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөн, мөн зүйлийн “2024 оны” гэснийг “2027 оны” гэж өөрчлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 39 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр,
Пүрэв гараг

Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
14 цаг 00 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Ирц. Ганибалын Амартүвшин гишүүн ирсэн байна. Хавдисламын Баделхан гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Салдангийн Одонтүяа гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн тул 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг танилцуулъя.

1. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх,

2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл эцсийн хэлэлцүүлэг,

3. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл эцсийн хэлэлцүүлэг,

4. “Тогтоолын хавсралтыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Төрийн аудитын байгууллагын

албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай асуудал байгаа. Хэлэлцэх,

5. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг гэсэн ийм 5 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, саналтай гишүүд байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж гишүүн танилцуулна. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин нарын хамт өргөн барьсан.

Тэгэхээр 2019 онд ашигт малтмалын нөөц ашигласны татварыг баяжуулах буюу боловсруулах салбарт дахин авахаар шийдвэрлэсэн нь бол энэ үйлдвэрлэлийн салбарт бас тодорхой хэмжээний хүндрэлийг бий болгосон. Тухайн үед бол нийтдээ 50 гаруй аж ахуйн нэгжүүд, 90 гаруй аж ахуйн нэгж ажиллаж байсан. Түүний 60 орчим нь бол өөрийн уурхайгүй аж ахуйн нэгжүүд баяжуулах, угаах болон ашигт малтмалыг дахин нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн болгох тэр салбарын ажил хийж байсан боловч одоо 30 гаруй нь хаалгаа барьсан ийм байдалтай байгаа.

Яагаад гэвэл ашигт малтмалын нөөц ашигласны татвар нь хилийн цаана

байгаа яг энэ төрлийн үйлдвэрүүдтэй өрсөлдөх ямар ч боломжгүй болсон гэсэн үг. Өөрөөр хэлбэл, жишээ нь жонши манайх шууд экспортлоод, хүдрээр нь экспортлоод Эрээнд гаргалаа гэхэд тэнд нэгхэн удаа АМНАТ төлдөг. Гэтэл дотооддоо баяжмал болголоо гэхэд дахин АМНАТ төлж байгаа нь бол энэ төрлийн үйлдвэрлэлийг цаашаа хөгжүүлэх боломжгүй, эдийн засгийн үр ашиггүй, өрсөлдөх чадваргүй болгож байгаа учраас энэ АМНАТ-ыг ингээж давхардуулж авч байгаа нь бол дэлхийд байхгүй ийм жишиг байна.

Тийм учраас энэ АМНАТ-ыг дахин боловсруулах салбарт авах нь буруу юм гэж үзээд Ашигт малтмалын тухай хуулийн 47.1-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан байгаа. 45.1.2-т ашигт малтмал экспортолсон этгээд гэдэгт АМНАТ төлөгдсөн хүдэр нүүрсийг худалдан авч, баяжуулж, боловсруулж, угааж, нэмүү өртөг шингээж агуулгыг дээшлүүлсэн бол хамаарахгүй гэдэг. Мөн 47.7-д АМНАТ-ын бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинээс хамаарч хүдэр баяжмал бүтээгдэхүүний аль нэг давхардуулахгүйгээр ногдуулна гэж өөрчлөн найруулах хуулийн төслийг өргөн барьсан байгаа.

Тэгээд энэ хуулийн төслийг хэлэлцэж баталбал нийтдээ 50 гаруй аж ахуйн нэгжүүд дахин үр дүнтэйгээр үйлдвэрлэлээ үргэлжлүүлэх, мөн түүнчлэн одоо 10 гаруй шинэ үйлдвэрүүд үүд хаалгаа нээхэд бэлэн болоод, энэ хуулийн өөрчлөлтийг хүлээж байгаа. Ингэсний үр дүнд нийтдээ 2000 гаруй ажлын байр бий болж, урьд нь орон нутаг, улсын төсөвт төлөгддөг байсан 50 гаруй тэрбум төгрөг улсын төсөвтөө, орон нутагтаа ордог болсны үр дүнд бол илүү эдийн засаг эрчимжиж, аж үйлдвэр шат шаттайгаар хөгжих ийм боломжийг бий болгоно гэж үзсэн.

Тийм учраас Их Хурлын гишүүд та бүхнийг энэ хуулийг хэлэлцэж,

дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүнд баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Санал хураалтыг явуулж эхэлье. Үүдэнд байгаа гишүүдийг дуудаж оруулаарай.

Би зүгээр хүмүүс орж иртэл яах вэ, ганц 2 зарчмын асуудлуудыг хэлчихье.

Ер нь бол АМНАТ буюу роялти энэ угаасаа 1 удаа л заавал төлөгдөх 1 талдаа зөвшөөрлийн төлбөр. Тэгэхээр бид бүхний хувьд бас нэг талдаа үүнийг давхардуулж авч байгаа асуудал бол угаасаа байж болохгүй. Олон улсын нийтлэг жишигээрээ байдаггүй асуудал.

Тэгэхээр бид нарын хувьд юу гэдэг юм магадгүй Монголын төрөөс гаргасан давхардуулж авдаг АМНАТ-тай холбоотой асуудлууд дээр бол алдаагаа засах ёстой. Эргээд энэ өөрөө бас гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх, үйлдвэрүүд босгох, ажиллахгүй болчихсон үйлдвэрүүд бас буцаж сэргэх боломж, бололцоо бүрдэх болов уу л гэж үзэж байна.

Гишүүд орж ирлээ. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

70 хувиар дэмжигдлээ.

Ингээд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Одонтүяа гишүүн танилцуулах уу, та. Баделхан дарга уу.

Би танилцуулчихъя.

Ингээд хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

14.09 цаг.

Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгахыг та бүхэнд бас тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Ингээд хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүд байна уу. Сандагаа дарга. Пүрэвдорж гишүүн танилцуулна.

Ингээд хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

14.10 цаг.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Та бүхэнд мөн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн төсөл болон хуулийн төслийг бэлтгэсэн талаарх танилцуулгыг тараасан байгаа.

Асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

14.11 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Загджав танилцуулна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Байнгын хорооны хуралдаанд оруулахыг хүсье.

Төрийн аудитын байгууллагаас төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг өөрчлөн тогтоолгох саналаа энэ 04 сарын 10-ны өдөр ирүүлсэн байна.

Ингээд дэгийн тухай хуулийн дагуу Төсвийн байнгын хорооноос “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” тогтоолын төслийг боловсруулсан.

Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа.

Танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Загджав танилцуулна. 3 номерын микрофоныг өгье.

Д.Загджав: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх үүрэг бүхий Улсын Их Хурлын харьяа байгууллага юм.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны бие даасан хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн хууль, эрх зүйн орчныг Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн аудитын байгууллагын тухай хуулиар баталгаажуулсан.

Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсэгт төрийн аудитын байгууллагын албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрдэх бөгөөд хувь хэмжээг нь Улсын Их Хурал тогтооно гэж заасан.

Төрийн аудитын байгууллагын алба хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 сарын 05-ны өдрийн 65 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, 07 сарын 01-ний өдрөөс хэрэгжилтийг ханган, Үндэсний аудитын газар, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын албан хаагчдын албан тушаалын цалинг мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Төсвийн байнгын хорооны 2020 оны 06 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг 496 байхаар тогтоосон. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 23 оны 117 дугаар тогтоолоор шүүх, прокурорын байгууллагын албан тушаалын цалин хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

Үүнээс харахад, Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалын цалин анхан шатын шүүхийн шүүгчээс 23 хувиар, аймаг, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын Хяналтын прокурорын албан тушаалын цалингаас 15 хувиар бага, орон нутагт Төрийн аудитын газрын албан тушаалын цалин нь аймаг, нийслэлийн анхан шатын шүүхийн шүүгчээс 61, аймаг, тээвэр, сум, дүүрэг, сум дундын прокурорын газрын Хяналтын прокурорын албан тушаалын цалингаас 61 хувиар тус тус бага байгаа юм.

Төрийн аудитын байгууллагын 2024 оны цалин, нийгмийн даатгалын батлагдсан төсөв 29,9 тэрбум төгрөг байна. Албан тушаалын албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэхэд нийт цалин, нийгмийн даатгалын зардалд 1,1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 31 тэрбум төгрөг, 60 хувиар нэмэгдүүлэхэд нийт 16 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдах бөгөөд энэ нь батлагдсан төсөвт багтаж байна.

Иймд төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын үндсэн цалинг нэмэгдүүлэхээр саналыг Төсвийн байнгын хороонд хавсралтаар хүргүүлснийг илтгэн танилцуулъя. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор гэсэн бүрэлдэхүүнтэй байгаа юм байна.

Тогтоолын төслийг гишүүдэд өгч байна уу. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Хавсралтууд ирнэ.

“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 65 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар өөрчлөн баталсугай.

Энэ тогтоолыг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоол байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Гишүүдийн нэрсийг авъя. Алга байна.

Би Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа Загджав даргаас 1 зүйлийг би тодруулж асуух гэсэн юм.

2 сарын өмнө Төсвийн байнгын хорооны даргын хувиар Төрийн аудитын байгууллага дээр ажилласан. Төрийн аудитын байгууллага болон хамт олон, удирдах бүрэлдэхүүнд нь би 2 үүрэг даалгавар өгсөн.

1 дүгээрт, Төрийн аудитын байгууллагын тухай хуульдаа өөрчлөлт оруулж, хамтын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, дээрээс нь энэ төрийн аудитын байгууллагын хараат бусаар ажиллах нөхцөл байдлыг бүрдүүлэх хуулийн өөрчлөлтийн төслийг өргөн барь гэдэг үүрэг даалгаврыг өгсөн.

2-т, манай энэ төрийн байгууллагууд дээр байдаг хяналт шалгалтын газар, хэлтэс, албад бас байдаг. Үүнтэй холбогдуулж Дотоод хяналтын тухай хуулийн төслийг бас

бэлтгэн боловсруулж, оруулж ир гэсэн үүрэг даалгаврыг өгсөн.

Төсвийн байнгын хорооноос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт нь хэр байна. 2 сарын хугацаа өнгөрсөн байна. Хэзээ оруулж ирэх, ямар явцтай, хэрэгжилт хэр хангагдаж байгаа, хуулийн төслүүд хэзээ бэлэн болох талаар бас тайлбар мэдээлэл сонсьё.

3 номер. Загджав дарга.

Д.Загджав: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллага дээр таны өгсөн үүрэг даалгаврын дагуу ажлын хэсгүүд гараад ажиллаж байна. Ер нь бол энэ том гол 2 асуудал байгаа.

1 нь, аудитын зөвлөлийн асуудал хөндөгдөж байгаа.

Нөгөө нь бол дотоод хяналт шалгалтыг сайжруулах, хөгжүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр. Энэ чиглэлээр манайх дотооддоо судалгаа хийхийн зэрэгцээ гадаад орнуудын туршилагыг судалж байна. Хамгийн түрүүн бид ОХУ-ын тооцооны танхимын туршилагыг судалъя гээд ажлын хэсгийг бас энэ 5 дугаар сард явуулахаар бэлтгэж байна. Зарим нэг Европын орнуудын туршилагыг бас судалсан байгаа. Азийн аудитын дээд байгууллагын ажилтай Филиппин, Тайланд явж бас судалсан. Тэгээд энэ 2 чиглэлээр хуулийн төслийг амжвал энэ Их Хурлын үед, амжихгүй бол намар оруулж ирэхээр төлөвлөн ажиллаж байгааг илтгэн танилцуулъя.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд асуулт асууя.

Б.Жавхлан: Загджав генералаас асуулт асууя. Одоо хуульдаа нөгөө цалинтай холбоотой асуудлыг оруулж байгаа биз дээ. Эд нар маань ингэчихсэн юм. Нөгөө Төрийн албаны хууль, Төрийн албан хаагчийн хууль дээрээс

хасагдчихсан. Одоо ТЗ ч биш, ТТ ч биш, ТҮ ч биш болчихоод байдаг. Гэтэл нөгөө бусад бүх төрийн байгууллагуудын төрийн албан хаагчдын цалин гээд нэмэгдээд яваад байдаг. Нэг үе бол аудиторчуудын цалин, бусад ТТ, ТЗ, ТҮ-ээс бол өндөр байсан. Тэгээд тийм ч байх хүний нөөцийн бодлого Засгийн газарт үеийн үед л байсан байгаа юм. Тэгээд одоо хоцроод эхэлсэн.

Тийм учраас одоо энэ хууль дээрээ нэгэнт хөндөгдөж байгаа бол цалингийнхаа асуудлыг дурдаад, тэгээд төрийн албан хаагч нарын цалин одоо цаашаа бол хуулиараа үнийн өсөлттэй уялдуулаад, инфляцтай уялдуулаад жил бүр шууд төсөв дээр нэмэгдээд явах ийм байдлаар хуульчлагдчихсан шүү дээ. Тэгээд тэр бүрдээ танайх хоцрох гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийгээ бас хуульчилж өгөөд төсөв өргөн баригдах, төсвийн тооцоолол хийж байх үед бас ордог байх хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ чинь жил бүр энэ асуудал чинь ингээд л давтагдаад л байна. Одоо ингээд 10 хувь ярьж байна. Тэрийг дэмжинэ бид нар. Эднийх хоцорчихсон байхгүй юу. Одоо энэ 10 хувиас ч хоцорчихно. Орон нутгийн нэмэгдлүүдээс ч хоцроод ингээд яваад байгаа.

Тийм учраас түүнд хамрагдах байдлаар энэ хуульдаа зохицуулалтаа нэг хөндөж байгаагийн хэрэг юу билээ, оруулаад авах хэрэгтэй шүү. Тэрийг хэлж байгаа юм. Одоо тэгээд ямар байдлаар тусгагдсан байгаа вэ.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 3 номер.

Жавхлан сайдын асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг.

Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5-д төрийн аудитын байгууллагын албан хаагчдын цалинг Улсын Их Хурлаас тогтооно гээд

заачихсан учраас сая төрийн албан хаагчдын цалингийн 10 хувийн нэмэгдэл бол бидний цалинг Улсын Их Хурлаас тогтоож байгаа учраас манай байгууллагад мөн үйлчлэхгүй байгаа.

Мөн орон нутагт ажиллаж байгаа төрийн аудитын байгууллагын албан хаагчдад орон нутгийн албан хаагчдад үйлчилж байгаа орон нутгийн нэмэгдэл буюу бусад нэмэгдлүүд бас төрийн аудитын байгууллагын хуульд байгаа энэ заалттай уялдаад өөрчлөгдөхгүй байгаа учраас албан хаагчдынхаа цалингийн асуудлыг оруулж ирж байгаа.

Манай төрийн аудитын байгууллага бол 498 албан хаагчтай. Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газруудад бас төрийн аудиторчууд ажиллаж байгаа ийм байгууллага учраас өнөөдрийн цалинтай холбоотой асуудлыг оруулж ирж байгаа юм.

04 дүгээр сарын 01-нээс манай төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын цалин нэмэгдээгүй хуучнаараа явж байгаа.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд нэмж тодруулъя.

Б.Жавхлан: Өөр бас нэг юм байгаа шүү, Нараа дарга аа. Танай нөгөө орон нутгийн аудиторчууд чинь орон нутгийн аудитын газрын дарга, Ерөнхий аудитор чинь төвөөсөө томилогддог. Ерөнхий аудиторынхаа тушаалаар томилогддог. Тийм учраас орон нутгийнх гэж үздэггүй юм байна лээ шүү. Үзэх боломжгүй болчихоод байгаа юм байна. Тэгэхээр орон нутгийн нэмэгдэл бас байхгүй хоцорчихоод байгаа байхгүй юу. Ийм хэд хэдэн асуудлууд байгаа. Ганц танайх ч биш. Жишээ нь УБЕГ-ынхан байна. Нөгөө улсын бүртгэгч гээд орон нутагт байдаг, сумд байдаг хүмүүс чинь энд нөгөө ерөнхий газраасаа томилогддог учраас сумын гэж тооцогддоггүй.

Тэгээд нөгөө сумд ажиллаж байгаа орон нутгийн нэмэгдэл ч байхгүй, аймгийн төв дээр ажиллаж байгаа орон нутгийн нэмэгдэл ч байхгүй хоцорч үлдээд байгаа юм. Тэр битгий хэл сумд ажиллаж байгаа татварын байцаагч нар ч байна. Сумынхаа ЗДТГ-т харьяалагддаггүй. Аймгийнхаа татварын газарт харьяалагддаг учраас бас нөгөө сумын орон нутгийн нэмэгдлүүдийг авах боломжгүй гэх мэт ийм албан тушаалтнууд байгаа. Тэр дотор танайх орчихсон явж байгаа шүү.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр гишүүдийн хэлсэн саяын саналуудыг бас анхаарч ажиллаарай.

Байнгын хорооноос бид нар бас өгсөн төрийн аудитын байгууллагад Үндэсний аудитын газар дээр хууль, эрх зүйн орчноо сайжруулах, нийгмийн баталгаатай холбоотой сайжруулах асуудлууд дээр анхаарч ажиллах ёстой.

I талдаа төрийн аудитын байгууллагын ажилчид, албан хаагч нар ачаалал ихтэй ажилладаг. Би энэ үүднээс төсвийн сахилга бат, хяналт, хариуцлагыг сайжруулах үүднээс та бүхнийг энэ дотоод хяналт шалгалтын хуулийг оруулж ир гэж хэлээд байгаа. Нэхээд байгаа. Асуудалд хариуцлагатай ханд аа. Үүрэг даалгаврыг заавал ч үгүй биелүүлэх ёстой.

Танай албан хаагч нар орон нутагт, төвд ажиллаж байгаа байгууллагын албан хаагч нар бүгд цаг хугацааны хайчинд ажилладаг. Ачаалал ихтэй байдаг. Тэгээд энэ ачааллыг нь бууруулах үүднээс бид нар энэ хуулийг нь оруулж ир гээд байгаа юм.

Дээрээс нь аудитыг цаглавраа өөрчил гээд байгаа юм. 25 хоногийн дотор аудит хийсэн болдог. Эргээд энэ болгон чинь цаг хугацааны хувьд боломжгүй болчихоод байна шүү дээ.

Дээрээс нь 3 дахь асуудал нь, аудитын байгууллага өөрөө энэ хяналт шалгалтаа хараат бусаар, бие даасан, хөндлөнгийн байдлаар хийх ёстой. Энэ нөлөөллийнхөө байдлыг эрх зүйн орчноо сайжруулах, аудитын байгууллага хараат бусаар дүгнэлт гаргах эрх зүйн орчныг хийх ёстой. Энэ даалгаврыг бас өгсөн.

Тэгэхээр энэ бол цэвэр дунд шатын болон бүх энэ төсвийн сахилга бат, хяналт, хариуцлагатай шууд хамааралтай асуудал. Та бүхний гаргаж байгаа ажлын үр дүнтэй шууд хамааралтай асуудал. Тэгэхээр үүнтэй холбогдуулж удирдлагынхаа тогтолцоог хамтын удирдлагын тогтолцоонд оруулах, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Үүнийг заавал ч үгүй оруулж ирэх үүрэг даалгаврыг өгч байгаа шүү. Явцаа хоёр 7 хоногийн дараа Төсвийн байнгын хороонд танилцуулаарай.

Ингээд санал хураалтыг явуулъя.

Бид бүхний хувьд та бүхнээс оруулж ирсэн энэ цалинтай холбоотой төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг төсөвт нь тааруулж, цалингийн хэмжээг өөрчлөлтийг хавсралтаар ингээд баталж байгаа.

Ингээд тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Тогтоолын төслийг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувиар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй санал гараагүй тул анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргаж байна.

Анхны хэлэлцүүлгээр нь баталъя, эцэслэн баталъя, батлахыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалт 70 хувиар дэмжигдлээ.

Пүрэвдорж гишүүн дэмжсэнээр орсон байгаа.

“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Сандаг-Очир гишүүн танилцуулах уу. Сандаг-Очир гишүүн.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

14.27 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж ажиллуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Сандаг-Очир гишүүн ажилласан байгаа. Ингээд ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Ц.Сандаг-очир: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ахалж, гишүүдэд Улсын

Их Хурлын гишүүн Булгантуяа, Тэмүүлэн нар ажиллалаа.

Ажлын хэсэг болон ажлын дэд хэсэг нь хуулийн төслөөр хөндөгдсөн асуудал болох татвар ноогдуулах зүйл буюу чихэрлэг ундаа, усны хэрэглээний талаар, уг бараанд ноогдуулсан онцгой албан татварын төсөвт төвлөрүүлсэн дүнгийн талаар, тухайн барааны стандартын талаар болон олон улсын туршилага судалсан дэд ажлын хэсгийн гишүүдээсээ мэдээлэл авах, санал солилцох зэргээр өнгөрсөн хугацаанд нийтдээ 4 удаа хуралдсан.

Хууль санаачлагч нарын төлөөлөл болох Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа ажлын хэсгийн хуралдаанд хүрэлцэн ирж мэдээлэл өгсөн.

Хууль санаачлагч Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлыг 2021 оноос эхлүүлсэн бөгөөд энэ хугацаанд ДЭМБ, Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, ЭМЯ, НЭМҮТ зэрэг нийтдээ 50 гаруй байгууллагатай хамтран ажилласан. Дэлхийн банкны шугамаар Австралийн Гриффит их сургуулийн доктор Юни Норт Каролина их сургуулийн доктор Австралид энэ чиглэлээр докторын зэрэг хамгаалж байгаа Нямдаваа нарын судалгаа, тооцооллыг төсөл боловсруулахад ашигласан.

Түүнчлэн хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Дэлхийн банкнаас “Чихэрлэг ундааны татварыг хэрэгжүүлж байгаа олон улсын туршилага, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, хэрэгжилт, анхаарах асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Уг хэлэлцүүлэгт ажлын дэд хэсгийн гишүүд, эрүүл мэндийн салбарын ажилтнууд, эм зүйч, эдийн засагч нар

оролцсон. Хэлэлцүүлгээс дараах дүгнэлтийг гаргасан. Үүнд:

1. Улс орны хөгжлийн түвшинээс үл хамаарч эрүүл мэндийн зардал өссөөр байна. Эм бол сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүн бөгөөд эмийн зөв хэрэглээг хүүхэд наснаас нь эхлэн ойлгуулах,

2-т, Чихэрлэг ундааны татварыг дэлхийн 100 гаруй улс орон хэрэгжүүлж байгаа бөгөөд тухайн бүтээгдэхүүний чихрийн агууламжийн хэмжээг нь тогтоож, татвар ноогдуулах нь зүйтэй,

3. Хуулийн хэрэгжилтэд хамрагдах ААН-үүдэд бизнесийн төлөвлөлтөө бодитой хийх, нөгөө талаар татвар, гааль, лабораторийн шинжилгээний чиг үүрэг хэрэгжүүлэх байгууллагуудын хүний нөөц болон үйл ажиллагааны бэлтгэл хангуулах зорилгоор хуулийн үйлчлэх хугацааг 2027 оноос эхлэн хэрэгжүүлэх,

4. Сүү, сүүн бүтээгдэхүүний чихэрлэг бодисын агууламжтай байхаас нь аль болох татгалзах зэрэг болно.

Ийнхүү ажлын хэсэг, ажлын дэд хэсгийн бэлтгэсэн танилцуулга болон хууль санаачлагчийн дээрх мэдээллийг сонссоны үндсэн дээр дараах агуулга бүхий зарчмын саналуудыг бэлтгэн Байнгын хороонд танилцуулж байна. Үүнд:

1. Татвар ноогдуулах зүйлийн нэршлийг оновчтой тогтоох нь зүйтэй гэж үзэн төслийн 4.1.5 дахь заалт буюу “чихрийн агууламж орсон хийжүүлсэн болон хийжүүлээгүй ус, ундаа” гэснийг “чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус” гэж өөрчлөх,

Хуулийг 2024 оноос хэрэгжүүлэхээр тусгагдсаныг 2027 оноос эхлэн хэрэгжүүлэхээр өөрчлөх,

3. Хуулийн төсөл нь Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт

оруулахаар байх тул төслийн нэрд өөрчлөлт оруулах, төслийн бүтцэд хуулийн техникийн засвар хийх зэрэг болно.

Эдгээр асуулттай холбогдуулан бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлээ. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүнд баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Ингээд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь санал хураалт явуулж эхэлье. Хуулийн төсөл 4 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг 1 саналтай.

1. Төслийн нэрийн “, өөрчлөлт” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Булгантуяа, Тэмүүлэн /цаашид “ажлын хэсэг” гэх/. Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн 4 дүгээр зүйлд, доор дурдсан агуулгатай 4.1.5 дахь хэсэг” гэснийг “хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт” гэж, 4.1.5 дахь заалтын дугаарыг “4.1.6” гэж тус тус өөрчлөн, мөн заалтыг төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт:

4.1.6. чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус.

Тайлбар: “төрөл бүрийн ундаа, ус” гэдэгт үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар ашиглах байгалийн гаралтай өтгөрүүлсэн шүүс, нунтаг баяжмал хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Пүрэвдорж гишүүн, микрофон өгье.

Б.Пүрэвдорж: Энэ кнопоо буруу дараад санал эсрэг гарчихлаа. Дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүний саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ. Өмнөх санал хураалтыг хүчингүй болгох санал

7	Чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус	1 литр
---	--	--------

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Амартүвшин гишүүн, микрофон өгье.

Г.Амартүвшин: Саяын санал хураалтаар санал хураалт маань орсонгүй. Тийм болохоор дахиж санал хурааж өгнө уу.

Г.Тэмүүлэн: Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Төслийн 3 дугаар зүйлийг 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг:

6.9.Энэ хуулийн 4.1.6-д заасан чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

	Онцгой албан татвар ногдуулах барааны	Биет	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/
--	---------------------------------------	------	--

хураалт дэмжигдсэн тул дахин санал хураалт явуулъя гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. Түүрүүн томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг 1 саналтай.

Төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 7 дахь заалт:

60 хувиар дэмжигдлээ. Амартүвшин гишүүний гаргасан дахин санал хураалгах санал дэмжигдсэн тул санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг нь 1 саналтай. Уншиж танилцуулъя.

Д/д	нэр, төрөл		нэгж	2027 он	2028 он	2029 он ба түүнээс хойш
1	Чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус	100 мл-т агуулагдах чихэр, чихэр орлуулагч 0-5 гр	1 литр	0	0	0
		100 мл-т агуулагдах чихэр, чихэр орлуулагч 5 гр-с дээш	1 литр	500 төгрөг	525 төгрөг	550 төгрөг

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн. 4 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгийн 1 саналтай.

Төслийн 4 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөн, мөн зүйлийн “2024 оны” гэснийг “2027 оны” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Ингээд хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ